

СОНО ФИНТЕК ББСБ ХХК-ИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны зарчим, бодлого, дотоод дүрэм, журам, Компанийн засаглал, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, зохицуулалттай аж ахуйн нэгжийн салбар дүрэм журмын хүрээнд “Соно финтек ББСБ” ХХК нь 2023 оны 12-р сарын 06 - ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж томилсон.

“Соно финтек ББСБ” ХХК нь урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгож, стратегийн зорилтуудад хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Бид эрсдэлийг илрүүлэх, судлах, оновчтой удирдах арга аргачлалыг боловсруулж, компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн, эрсдэлийг илэрхийлэх индикаторууд, зээлийн харьцаа үзүүлэлтүүд, үйл ажиллагааны хяналт болон тайлагналын тогтолцоог тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн засаглал нь компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилгод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм. Компанийн сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь “Соно финтек ББСБ” ХХК-ийн цаашдын эрхэм зорилго байна.

Компанийн сайн засаглал гэдэгт:

- Системтэй шийдвэр гаргах үйл явцтай байх
- Хариуцлагын талаар ойлголт өгөх
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх
- Дотоод хяналтыг сайжруулах
- Эрсдэлийн удирдлага
- Ил тод байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа багтана.

Компанийн засаглалын тухайн хэсэгт “Соно финтек ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн эрх үүрэг, хариуцлага, санхүүгийн тайлагналтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар тусгалаа.

Эрх мэдэл, хариуцлагын хуваарилалт

Компанийн хяналт болон удирдлага нь хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар), Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“Соно финтек ББСБ” ХХК-ийн эрх барих дээд байгууллага нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал” юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Үүнд:

1. Компанийн тухайн оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн тухайн оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн тухайн оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. ТУЗ-ийн тухайн жилийн үйл ажиллагааны зардлын төсөв батлах гэх мэт

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц

Компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь 5 гишүүнтэй байхаас 2 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ. Компанийн засаглалын кодекссын дагуу ТУЗ-д аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг хараат бус гишүүнээр сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь компанийн үйл ажиллагаа, хөгжлийн үе шаг болоод бусад нөхцөлтэй уялдсан байх шаардлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагаа

“Соно финтек ББСБ” ХХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин удирдан чиглүүлж ажилладаг. Жилийн төлөвлөгөө, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалт, гүйцэтгэх удирдлага томилох зэрэг асуудал нь ТУЗ-өөр хянагдан, батлагдана. ТУЗ нь санхүүгийн болон стратегийн бусад зорилт, бизнесийн гол сорилтууд, эрсдэл, бизнесийн хөгжил, хөрөнгө оруулалтын харилцааны гүйцэтгэлийн тайланг тогтмол хянах үүрэгтэй.

Мөн компани нь ТУЗ-ийн гишүүдийг бүх түвшинд удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй харилцах, холбогдох бүх мэдээлэлд хандах боломжоор ханган ажиллаж байна. ТУЗ нь 2024 онд 2 удаа ээлжит, 4 удаа ээлжит бус, нийт 6 удаа хуралдаж 10 тогтоол, шийдвэр гаргаж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ ийн дэргэдэх хороодын журмыг хэлэлцэн батлах
- Бизнесийн ёс зүйг хэрэгжүүлэх, авилгын эсрэг, соён гэгээрүүлэх чиглэлд Ёс зүйн дүрсмийг шинээр хэлэлцэн батлах
- ТУЗ -ийн бүтэц чиг үүрэг, удирдлагын цалин хөлс
- Компанийн засаглалын кодекссын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх, СЗХ-нд хүргүүлэх тухай
- Комплайнсын хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, албан тушаалтныг томилох

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Засаглалын кодекссыг хангах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэд туслах ажлын хэсгүүдийг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнаж, зөвлөмжийг хүргүүлэхээр зохицуулсан

Аудитийн хороо

Компанийг стратеги зорилго, зорилтдоо амжилттай хүрэхэд дэмжлэг үзүүлж, учирч болох эрсдэлийг тодорхойлж, эрсдлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, чиглүүлэх ба дараах үндсэн чиг үүрэгтэй байна.

1. Хууль эрх зүй, бизнесийн орчин, зах зээл дээр үүсч болох аливаа эрсдлийг урьдчилан тооцоолох, бүх төрлийн шинжилгээ судалгаа хийх, болзошгүй эрсдлийг удирдах, хянах, арга замыг тодорхойлох, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах.
2. Компанийн удирдлагын багийг эрсдлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах,
3. Компанийн дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөг хянаж баталгаажуулах.
4. Дотоод хяналтын хэлтсийн баримт бичиг, бодлого, журам, зааврыг хянах, удирдлагаар хангах.
5. Дотоод хяналтын нэгжийн бүтэц, орон тоо, цалин урамшууллын зардлыг тооцоолж ТУЗ-өөр хэлэлцүүлж батлуулах.
6. Дотоод хяналтын нэгжийн тайлантай танилцаж, аудитад хамрагдаж буй нэгжүүдтэй үр дүнтэй харилцаж, аудитын эцсийн дүгнэлтэд эрсдэлд суурилсан баталгаажуулалт өгөх.
7. Компаний дотоод болон хөндлөнгийн аудитын төлөвлөгөөг гаргах, баталгаажуулалтыг ТУЗ-д танилцуулах.

Бизнес хөгжил, судалгааны хороо

Компанийн тухай хуулийн 81.2 -т заасан Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх ба дараах үндсэн чиг үүрэгтэй байна.

1. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг боловсруулж ТУЗ -өөр батлуулах.
2. Залгамж халааны бодлогыг боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах.
3. Компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ -ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцах.
4. ТУЗ -ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх.

5. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх.
6. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах.
7. ТУЗ -ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах.
8. Зах зээлийн нөхцөл байдлыг судлах, үнэлж дүгнэх, бодлого боловсруулах, бизнесийн үнэ цэнийг өсгөх.
9. Санхүү, эдийн засгийн аливаа түвшний судалгаа шинжилгээг хариуцах
10. Компаний зах зээл эзлэлт, нэр хүнд, өсөлт хөгжлийг нэмэгдүүлэх ажлыг удирдан хийх.

Мэдээлэл технологи, хөгжүүлэлтийн хороо

Компанийн бүхий л түвшинд мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг удирдах ба дараах үндсэн чиг үүрэгтэй байна.

1. Компанийн мэдээллийн технологийн өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах бодлогыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах.
2. Компанийн цахим орчинд аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэн, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах.
3. Компанийн мэдээллийн технологи, эх өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйнд суурилсан платформууд, шаардлагатай программ хангамжийн үйлчилгээг нэвтрүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлэх.
4. Компанийн мэдээллийн технологийн шинэчлэлт, инновацыг нэвтрүүлэх замаар өнөөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх төрлийн бодлого, баримт бичиг боловсруулах, ТУЗ-өөр батлуулах, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих.
5. Компанийн мэдээллийн технологийн хөгжүүлэлт, шинэчлэлт, шийдэл, нэвтрүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөх, зөвлөх, дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах, дүгнэх, ТУЗ-ын дэргэдэх бусад хороодтой энэ чиглэлд хамтран ажиллах.
- 6.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭ

Бүлэг	ЗАРЧИМ, ЗҮЙЛ	Шаардлагын тоо	Авбал зохих оноо	СЗХ Үнэлсэн оноо	СЗХ Үнэлгээний хувь
I	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	6	12	10	83%
II	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	5	10	10	100%
III	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	3	6	4	67%
IV	Аудит, хяналтын тогтолцоо	3	6	5	83%
V	Эрсдэлийн удирдлага	4	8	7	88%
VI	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	3	6	4	67%
VII	Оролцогч талуудын эрх ашиг	4	8	6	75%
VIII	Компанийн соёл	3	6	6	100%
IX	Хувьцаа эзэмшигчдийн эрх	5	10	10	100%
НЭГДСЭН ДҮН		36	72	62	85%